

БАЙГАЛИЙН УРГАМАЛТАЙ ХОЛБООТОЙ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

ХБОБНУГ-ын мэргэжилтэн Г.Оюунгэрэл

Монгол орны ургамлын аймагт одоогоор 39 баг, 112 овог, 683 төрөлд хамрах 3127 дээд ургамал, 113 овог 3035 зүйлийн доод ургамал бүртгэгдсэн байна. /1574 замаг, 1030 зүйл хаг, 500 зүйл хөвд, 470 зүйлийн мөөг/



Нэн ховор: байгалийн жамаар нөхөн сэргэх чадваргүй, тархац нэн хязгаарлагдмал, ашиглах нөөцгүй, устах аюулд орсон
Ховор: байгалийн жамаар нөхөн сэргэх чадвар хязгаарлагдмал, тархац, нөөц багатай, устаж болзошгүй ургамал
Элбэг: Дээрхи ангилалд оруулснаас бусад

Загийн газрын 1995 оны 153, 2004 оны 165, 2015 оны 410 дугаар тогтоолоор 355 зүйл ургамлыг ховор ургамлын жагсаалтад оруулсан.

Mongolian Red List and Conservation Action Plans of PLANTS



148 зүйл ургамлыг үнэлснээс
100 зүйл нь ховордлын зэрэгт
16 зүйл устаж байгаа
39 зүйл устаж болзошгүй ангилалд
55 зүйл эмзэг ангилалд тус тус оржээ

Устах аюулд орсон нэн ховор, устаж болзошгүй ховор ургамлыг судалгаагаар тогтоож 195 зүйл ургамлыг "Монголын улаан ном"-д бүртгэсэн



Холбогдох хууль эрх зүйн актууд



Байгалийн ургамлын тухай хууль

3.2. Ургамлыг түүний нөөц, нөхөн сэргэх чадварыг нь харгалзан:



Нэн ховор

11.1. Иргэн, ААН байгууллагад Судалгаа шинжилгээний зориулалтаар түүх зөвшөөрлийн

11.1. Судалгаа шинжилгээний зориулалтаар, 13.3. Эм үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах

Ховор



12. Иргэн ховор ургамлыг өөрийн ам бүлийн хүнсний болон ахуйн бусад хэрэгцээг хангах зорилгоор сум, дүүргийн Засаг даргын зөвшөөрлөөр ашиглаж болно

Элбэг

13.3. Элбэг ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах зөвшөөрлийг аймаг, нийслэлийн байгаль орчны албаны дүгнэлтийг үндэслэн сум, дүүргийн Засаг дарга

10. Ургамлыг ашиглах зориулалт

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нэн ховор ховор ургамлыг зөвхөн судалгаа, шинжилгээний, ховор ургамлыг ахуйн болон судалгаа, шинжилгээний, элбэг ургамлыг судалгаа, шинжилгээний, ахуйн үйлдвэрлэлийн зориулалтаар тус тус ашиглаж болно.





7¹.4 Үйлдвэрлэлийн зориулалтаар түүж бэлтгэж болох ургамлын төрөл, зүйлийн нэр, түүх дээд хязгаарыг төрийн захиргааны төв байгууллага жил бүр тогтооно.

15.1. Үйлдвэрлэлийн зориулалтаар ургамал ашиглах иргэн, аж ахуйн нэгж, байгууллага байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг өөрийн зардлаар хийлгэж, тухайн ургамлын нөөцийн хэмжээг тогтоолгож, ашиглахыг хүсч буй ургамлын зүйлийн нэр, эрхтэн, ашиглах зориулалт, хэмжээ, хугацаа, нөхөн сэргээх арга хэмжээг тусгасан төсөл боловсруулан холбогдох мэргэжлийн байгууллагаар хянуулж ургамлыг ашиглах зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага буюу албан тушаалтанд өгнө


9 дүгээр зүйл. Ургамлыг нөхөн сэргээх

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ургамлыг нь үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан газраа зохих журмын дагуу өөрийн хөрөнгөөр нөхөн сэргээх буюу нөхөн сэргэх нөхцлийг бүрдүүлсний дараа сум, дүүргийн Засаг даргад хүлээлгэн өгнө.

11.2. Судалгаа, шинжилгээ, ахуйн зориулалтаар ашиглахаар түүж бэлтгэсэн ургамлыг үйлдвэрлэлийн түүхий эд болгон ашиглах, орлого олох зорилгоор бусдад борлуулахыг хориглоно.

Байгаль орчныг хамгаалах тухай хууль

3.2.11. “Байгаль орчинд учруулсан хохирол” гэж байгалийн баялгийг зөвшөөрөлгүй бэлтгэсэн, олборлосон, эсхүл байгаль орчны чадавхын тогтоосон хэм хэмжээ, зөвшөөрөгдөх дээд хэмжээний хязгаараас хэтрүүлэн байгаль орчныг бохирдуулсан, доройтуулсан, гэмтээсэн, байгалийн нөөц баялгийг хомсдуулсан, экологийн тогтолцоог алдагдуулсан аливаа үйлдэл, эс үйлдэхүйг;



49 дүгээр зүйл. Байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлөх
49.4.3. Ургамлын аймагт учирсан хохирлыг тухайн ургамлын экологи–эдийн засгийн үнэлгээг тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр;

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль

14 дүгээр зүйл Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээ

Төлбөр ногдох байгалийн ургамал	Төлбөр тооцох үзүүлэлт дэх экологи-эдийн засгийн үнэлгээний хувь	
	Доод	Дээд
1.Нэн ховор	25	30
2.Ховор	15	20
3.Элбэг	5	10

14.2. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас энэ хуулийн 14.1-д заасан төлбөрийн хэмжээний хязгаарт багтаан ургамлын нөөц, тархац, ач холбогдол, ашиглагдах эрхтний онцлог, зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн байдлыг харгалзан ургамлын нэр төрөл тус бүрээр төлбөрийн хэмжээг тогтооно.

18.1. Энэ хуулийн 13.2-т /байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлого/-заасан төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь, хэмжээний доод хязгаарыг дараах байдлаар тогтооно:

Байгалийн баялгийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төрөл	Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хувь, хэмжээний доод хязгаар /нийт орлогын дүнгээс хувиар/
1. Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлого	15 хувь

19 дүгээр зүйл. Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөх

- 19.1.Дараах зориулалт, хэрэгцээгээр байгалийн ургамлын нөөц ашигласан төлбөр төлөгчийг төлбөрөөс чөлөөлнө:
 - 19.1.1.элбэг ургамлыг ахуйн хэрэгцээнд ашигласан иргэн;
 - 19.1.2.ховор болон элбэг ургамлыг судалгаа шинжилгээний зориулалтаар ашигласан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага;
 - 19.1.3.тариалангийн бүс нутгаас бусад нутагт байгалийн ургамлыг хадлан бэлчээрийн зориулалтаар ашигласан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага.
 - 19.1.4.тариалангийн бүс нутагт байгалийн ургамлыг эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага.
- 19.2.Элбэг ургамал ашигласны төлбөрийг хөнгөлж болох бөгөөд төлбөрийг хөнгөлөх нөхцөл, болзол, хувь, хэмжээг тухайн орон нутгийн нөхцөл, онцлог байдлыг харгалзан аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль

21 дүгээр зүйл.Байгаль орчны чиглэлээр эрхлэх үйл ажиллагаанд зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ

- 21.1.13.ховор ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэн гадаадад гаргахад тухайн үеийн хуурай жингийн килограмм тутамд 1200-3000 төгрөг, тарималжуулсан нэн ховор, ховор ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэн гадаадад гаргахад тухайн үеийн хуурай жингийн килограмм тутамд 600-1500 төгрөг;
- 21.1.15.элбэг ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэн гадаадад гаргахад тухайн үеийн жингийн килограмм тутамд 1000-2500 төгрөг;
- 21.1.16.нэн ховор ургамлын эд, эрхтэнийг судалгаа, шинжилгээний зориулалтаар ашиглах зөвшөөрөл олгоход килограмм тутамд:
 - 21.1.16.а.үр 60 000- 150 000 төгрөг;
 - 21.1.16.б. навч, найлзуур, иш 18 000- 45 000 төгрөг;
 - 21.1.16.в.үндэс 100 000 - 250 000 төгрөг.
- 21.1.17.ховор ургамлыг эмийн үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах зөвшөөрөл олгоход хуурай жингийн килограмм тутамд 4000-10000 төгрөг, ховор ургамлыг гадаадад гаргах зөвшөөрөл олгоход хуурай жингийн килограмм тутамд 6000-15 000 төгрөг, түүхий эд бүтээгдэхүүн 20 000-50 000 төгрөг;
- 21.1.18.элбэг ургамлыг гадаад улсад гаргах зөвшөөрөл олгоход 0-3 килограмм бол 1800-4500 төгрөг, 3 килограммаас дээш бол 1800-4500 төгрөг дээр 3 килограммаас дээш хуурай жингийн килограмм тутамд 600-1500 төгрөг нэмж;

Засгийн газрын 2011 оны 199 дүгээр тогтоолоор батлагдсан “Тэмдэгтийн хураамжийн хувь, хэмжээ”

- Арван нэг. Байгаль орчны чиглэлээр эрхлэх үйл ажиллагаанд зөвшөөрөл олгоход хураах тэмдэгтийн хураамжийн хэмжээ

11.1.12. ховор ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэн гадаадад гаргахад тухайн үеийн хуурай жингийн килограмм тутамд 3000 төгрөг, тарималжуулсан нэн ховор, ховор ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэн гадаадад гаргахад тухайн үеийн хуурай жингийн килограмм тутамд 1000 төгрөг;

11.1.14. элбэг ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэн гадаадад гаргахад тухайн үеийн жингийн килограмм тутамд 1000 төгрөг;

11.1.15. нэн ховор ургамлын эд, эрхтэнийг судалгаа, шинжилгээний зориулалтаар ашиглах зөвшөөрөл олгоход килограмм тутамд:

11.1.15.а. үр 150 000 төгрөг;

11.1.15.б. навч, найлзуур, иш 30 000 төгрөг;

11.1.15.в. үндэс 120 000 төгрөг.

11.1.16. ховор ургамлыг эмийн үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах зөвшөөрөл олгоход хуурай жингийн килограмм тутамд 4000 төгрөг, ховор ургамлыг гадаадад гаргах зөвшөөрөл олгоход хуурай жингийн килограмм тутамд 10 000 төгрөг, түүхий эд бүтээгдэхүүн нь 30 000 төгрөг;

11.1.17. элбэг ургамлыг гадаад улсад гаргах зөвшөөрөл олгоход 0-3 килограмм бол 3000 төгрөг, 3 килограммаас дээш бол 3000 төгрөг дээр 3 килограммаас дээш хуурай жингийн килограмм тутамд 600 төгрөг нэмж;

Зөрчлийн тухай хууль


7.7 дугаар зүйл. Байгалийн ургамлын тухай хууль зөрчих



1. Зохих зөвшөөрөлгүйгээр, эсхүл зөвшөөрөлд заасан хугацаа, хэмжээ, ургамал түүж бэлтгэх журам зөрчиж:

1.1. байгалийн ховор ургамлыг ахуйн хэрэгцээнд;

1.2. элбэг ургамлыг үйлдвэрлэлийн түүхий эд болгон ашиглах, орлого олох зорилгоор түүсэн, бэлтгэсэн, худалдсан бол



хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах ач холбогдолтой нутаг дэвсгэр, бэлчээр, хадлангийн газар, мал тэжээх зориулалтаар ашиглахыг хориглосон газар үйлдвэрлэлийн зориулалтаар ургамал түүж бэлтгэсэн, эсхүл мал бэлчээсэн бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4.Ургамлыг түүж бэлтгэх журам зөрчсөн, эсхүл ахуйн зориулалтаар ашиглахаар түүж бэлтгэсэн ургамлыг үйлдвэрлэлийн түүхий эд болгон ашигласан бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Эрүүгийн тухай хууль

24.8 дугаар зүйл. Байгалийн ургамлыг хууль бусаар бэлтгэх

1. Зохих зөвшөөрөлгүйгээр, хуульд зааснаас өөр зорилгоор нэн ховор, ховор ургамал, тэдгээрийн үр, эрхтэнийг түүсэн, бэлтгэсэн, худалдсан, худалдан авсан, хадгалсан, тээвэрлэсэн, боловсруулсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

• 24.9 дүгээр зүйл. Байгалийн тэнцэл алдагдуулах

1. Амьтан, ургамлын зүйлийг зөвшөөрөлгүйгээр гэмтээсэн, устгасан, газар, газрын хэвлий, агаар мандал, усны нөөцийг хордуулсан, бусад хэлбэрээр экологийн тогтолцоог алдагдуулсан бол найман жилээс арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2. Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг нэг зуун хорин мянган нэгжээс дөрвөн зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ

- Байгалийн ургамлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, батлуулах;
- Монгол орны хэмжээнд байгалийн ашигт ургамлын тархац, нөөцийг шинэчлэн тогтоох;
- Нэн ховор, ховор ургамлын жагсаалтыг шинэчлэн тогтоох;

АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАРЛАЛАА